

САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Д.Моломжамц*, **Б.Хишигдэлгэр****, **Н.Дамдиндорж*****

Хураангуй: Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн үр дүнд бэлтгэгдсэн санхүүгийн тайлангуудад тусгагдсан ихээхэн хэмжээний тоо мэдээг боловсруулж санхүүгийн тоо мэдээллийг хэрэглэгчдэд тайлбарлан ойлгуулах, эдийн засгийг шийдвэр гаргахад нь тусалдаг чухал арга хэрэгсэл бол санхүүгийн шинжилгээ, түүний арга зүй юм. Санхүү, эдийн засгийн шинжилгээ нь эдийн засгийн тоо мэдээллийг хамрах хүрээ, цаг хугацаа, эрхлэн гүйцэтгэж буй этгээд зэргээс хамааран олон төрөл хэлбэртэй байхын зэрэгцээ хөгжлийн олон үе шатыг туулж дэлхийн улс орнуудын улс төр-эдийн засгийн онцлог, компанийн засаглал, НББОУС-ыг хүлээн зөвшөөрөх үйл явц, хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн загварын онцлог зэргээс шалтгаалан хэд хэдэн чиглэлээр хөгжиж байна.

Энэхүү өгүүлэлд манай улсад хөгжиж ирсэн санхүү, эдийн засгийн шинжилгээний төрөл хэлбэр, цаашдын чиг хандлагыг дэлхийн бусад улс оронд хөгжүүлж буй сүүлийн үеийн шинжилгээний төрөл чиглэл, хандлага, арга зүйтэй уялдуулан авч үзсэн болно.

Түлхүүр үгс: балансын эдийн засгийн шинжилгээ, санхүүгийн тайлангийн шинжилгээ, санхүүгийн шинжилгээ, санхүү-эдийн засгийн шинжилгээ

Abstract: Financial analysis and its methodology are important tools for processing large amounts of corporate data in the financial statements prepared as a result of bookkeeping, helping consumers to understand financial information and make economic decisions. Financial and economic analysis can take many forms that depending on the scope, timing, and entity of the economic data. It has gone through many stages of development, depending on the political and economic characteristics of the countries of the world, corporate governance, the process of recognizing IAS, and the specifics of the accounting model used.

This article discusses the types of financial and economic analysis that have been developed in our country and further trends are considered with the latest research trends, approaches and methodologies being developed in other countries in the world.

Key words: economic balance analysis, financial statement analysis, financial analysis, financial and economic analysis,

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): molomjamts0112@yahoo.co.jp

** МУИС-ийн ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбар, (E-mail): mongoliabkd@gmail.com

*** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): maidaa0055@yahoo.com

Оршил

Санхүү, эдийн засгийн шинжилгээний судалгааны үндсэн бааз суурь нь санхүүгийн бүртгэл тайлангийн мэдээлэл юм. Иймээс санхүү, эдийн засгийн шинжилгээний хөгжлийн чиг хандлагыг нягтлан бодох бүртгэлийн хэв загвар, төрөл, онцлогийг харгалзахгүйгээр авч үзэх боломжгүй. Олон улсын байгууллагууд түгээмэл мөрддөг бүртгэлийн стандарттай уялдуулан нягтлан бодох бүртгэлийн системийг дэлхийн түвшинд ижилсүүлэх оролдлогыг хийж байгаа боловч улс орнуудын нягтлан бодох бүртгэлийн системд ихээхэн ялгаа оршоор байна. Дэлхийн улс орнууд ийнхүү нягтлан бодох бүртгэлийн үндэсний онцлогоо хадгалсаар байгаа нь санхүү, эдийн засгийн шинжилгээний нэг хэв маяг, стандартыг мөрдөхөд бэрхшээл учруулж байна гэж үздэг. Өнөө үед улс орнуудад нягтлан бодох бүртгэлийн дөрвөн үндсэн загвар хэрэглэгдэж байгаатай уялдаж тэдгээрт тулгуурлан хийгдэх санхүү, эдийн засгийн шинжилгээний арга зүй нь харилцан адилгүй байна.

Хүснэгт 1. Нягтлан бодох бүртгэл, шинжилгээний загвар

Загвар	Нягтлан бодох бүртгэлийн төрөл	Шинжилгээний төрөл
Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт	Санхүүгийн бүртгэл, Удирдлагын бүртгэл	Санхүүгийн шинжилгээ
Англи-Саксоны загвар	Санхүүгийн бүртгэл, Удирдлагын бүртгэл	Санхүүгийн шинжилгээ
Европын загвар	Ерөнхий	Санхүү, эдийн засгийн шинжилгээ
Зүүн Европын загвар	Нэгдсэн	Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ

Барууны ихэнх орнуудад хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн загварыг үндсэнд нь хоёр хувааж үздэг. Үүнд:

1. Англи-Саксоны загвар
2. Европ тивийн загвар

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нь Англи-Саксоны загвартай, Зүүн Европын социалист загвар нь Европ тивийн загвартай үндсэндээ ижил төстэй бөгөөд дээрх хоёр үндсэн загвараас үүсч хөгжсөн гэж үздэг.

Англи-Саксоны загвар бүхий улс орнуудын бүртгэлийн онцлог нь:

- Аж ахуйн нэгж бүр өөрийн дансны төлөвлөгөөг зохиож ашигладаг.
- Орлогын тайлан нь дараах шинжийг агуулсан байдаг. Үүнд:

- (а). Үйлдвэрлэлийн концепци нь борлуулсан бүтээгдэхүүнд суурилдаг. Борлуулсан бүтээгдэхүүний үзүүлэлт нь тухайн жилийн бүх борлуулалт, түүний дотор зээлээрх борлуулалтыг багтаадаг.
- (б). Зардлыг функцээр нь ангилж авч үздэг. Үүнд: борлуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал буюу борлуулсан бүтээгдэхүүний өртөг /үйлдвэрлэлийн функц/, маркетингийн зардал /хуваарилалтын функц/, удирдлагын зардал болон бусад зардал ба татвар /санхүүгийн функц/ гэх мэт.
- Тайлан баланс нь тухайн аж ахуйн нэгжийн төлбөрийн чадварыг илэрхийлэх зорилгыг агуулсан байдаг. Үүнд:
 - (а). Активын зүйл ангиуд нь хөрвөх чадвараараа ангилагдсан байна.
 - (б). Пассивын зүйл ангиуд нь төлж барагдуулах дэс дараалаар, мөн хугацаагаар ангилагдсан байна.

Ийм загварт үндэслэсэн шинжилгээ нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийг харьцуулах, зардлын функцийг үнэлэхэд гол төлөв анхаарахын зэрэгцээ төлбөрийн чадвар, санхүүгийн тогтворжилт зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж бусад компаниудтай харьцуулан дүгнэлт өгөхөд оршино.

Европ тивийн загвар бүхий улс орнуудын бүртгэлийн онцлог нь:

- Улс орны хэмжээнд дансны нэгдсэн төлөвлөгөөг зохиож ашигладаг.
- Орлогын тайлан нь дараах үндсэн шинжийг агуулсан байдаг. Үүнд:
 - (а). Үйлдвэрлэлийн концепци нь тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнд суурилдаг.
 - (б). Зардлыг гарал үүслээр нь ангилдаг.
- Тайлан балансын зүйл ангиудын ангилалт нь хууль зүйн шалгуураас үүсэлтэй. Үүнд:
 - (а). Активын зүйл ангиуд нь үндсэн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын зардлаас эхлэн ангилагдсан байна.
 - (б). Пассивын зүйл ангиуд нь өөрийн капиталаас эхлэн ангилагдах бөгөөд өр төлбөрийг санхүүгийн өр, бэлтгэн нийлүүлэгчийн өр, нийгмийн даатгалын өр, татварын өр гэх мэтээр ангилсан байна.

Ийм загварт үндэслэсэн шинжилгээ нь гарал үүслээрээ ангилагдсан янз бүрийн зардлуудыг нийт бүтээгдэхүүнтэй нь харьцуулах, нэмэгдсэн өртгийг үнэлэх, түүнийг ажилчид, зээлдүүлэгчид, компани, төр засаг зэрэг янз бүрийн талуудын хооронд хуваарилахад гол төлөв анхаарахын зэрэгцээ үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, зах зээлийн идэвхжил зэрэг санхүүгийн харьцаануудыг тодорхойлон бусад компаниудтай харьцуулан дүгнэлт өгөхөд

оршино.

Нягтлан бодох бүртгэлийн загваруудын ийм ялгаа, ялангуяа бэлтгэж байгаа санхүүгийн тайлангуудын хэв маяг, арга зүйн зөрүүтэй байдал нь түүнд тулгуурлан хийж байгаа санхүүгийн шинжилгээний арга зүйд нөлөөлөх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, нягтлан бодох бүртгэлийн ямар загварыг ашиглаж байгаагаас хамаарч түүнд тохирсон санхүүгийн шинжилгээний арга зүйг ашигладаг байна. Тухайлбал, энэ талаар “Ихэнх санхүүгийн коэффициентуудыг орлогын тайлан ба баланс гэсэн хоёр үндсэн хэлбэрийн санхүүгийн тайлангийн тоо мэдээг ашиглан тооцоолдог” (Панков,1998) гэсэн бол “Санхүүгийн тайлангийн шинжилгээнд үйлдвэрийн газрын бүртгэлийн систем, санхүүгийн тайлангийн тоо мэдээ нь хамгийн чухал байна” (Бернстайн,1996) зэргээс үзвэл шинжилгээний арга зүй нь нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандарт, бэлтгэж байгаа санхүүгийн тайлангийн хэв загвартай нягт уялдаатай болохыг харуулж байна.

Манай улс 1990-ээд оноос НББОУС-ыг нэвтрүүлснээр санхүүгийн бүртгэлийн тогтолцоо үндсэндээ бүрэлдэн тогтсон бөгөөд өөрийн орны бүртгэлийн онцлог, санхүүгийн хэв загварт тохирсон шинжилгээний арга зүйг боловсруулж ашиглаж байна.

Бүртгэл шинжилгээний талаарх ном зохиолуудад эдийн засгийн шинжилгээ, аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ, санхүүгийн шинжилгээ, санхүү-эдийн засгийн шинжилгээ, санхүүгийн тайлангийн шинжилгээ зэрэг нэр томъёонуудыг өргөн ашиглаж байна. Эдгээр нь өөр хоорондоо төстэй ойлголтууд хэдий ч өөрийн өвөрмөц онцлог бүхий агуулга, бүтэц, зорилго зорилтыг илэрхийлж байдаг.

Ерөнхийдөө барууны эрдэмтдийн шинжилгээний талаарх ном, бүтээлүүдэд санхүүгийн шинжилгээ ба санхүүгийн тайлангийн шинжилгээ гэсэн нэр томъёонуудыг өргөн хэрэглэсэн байдаг. Үүнд санхүүгийн шинжилгээний судлах зүйл, арга зүй нь харьцангуй өргөн хүрээтэй, тухайлбал санхүүгийн менежерүүдээс компанийг амжилттай удирдахын тулд санхүүгийн активуудыг оновчтой байршуулах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг бүрдүүлэх зэрэг компанийн санхүүгийн байдлыг бүхэлд нь үнэлэхтэй холбоотой шинжилгээ судалгааг түлхүү авч үзсэн байх бөгөөд түүнчлэн эдгээртэй холбогдсон санхүүгийн тайланг шинжлэх арга зүйг авч үзсэн байдаг.

Тухайлбал, санхүүгийн шинжилгээний судлах зүйл, зорилго, хамрах хүрээний талаар “Аливаа бизнес бол ямар нэг удирдлагын шийдвэрээр идэвхждэг санхүүгийн нөөцүүдийн хөдөлгөөнтэй харилцан холбоотой систем юм. Бизнесийн системийг тайлбарлах санхүүгийн шинжилгээний үндсэн зарчим нь

санхүүгийн нягтлан болох бүртгэл, хөрөнгө оруулалтын шинжилгээ, капиталын удирдлага байна” (Helfert, 1994), “Санхүүгийн шинжилгээний судлах зүйл нь санхүүгийн нөөц ба түүний урсгал юм. Санхүүгийн шинжилгээний үндсэн зорилго ба агуулга бол санхүүгийн оновчтой бодлогын тусламжтайгаар аж ахуйн субъектийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх боломжийг илрүүлэх ба санхүүгийн байдлыг үнэлэх явдал юм” (Ковалев, 1998), “Орчин үед санхүүгийн менежерүүдийн өмнө хоёр чухал асуудал тулгарч байна. Үүнд:

1. Активын ямар төрөлд ямар хэмжээний хөрөнгө оруулалт хийхийг тодорхойлох;
2. Хөрөнгө оруулахын тулд ямар эх үүсвэрийг ямар аргаар олж авах гэдгийг тодорхойлох, эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн шинжилгээ чухал ач холбогдолтой” (Радионов, 1999) гэсэн байна.

Харин санхүүгийн тайлангийн шинжилгээний судлах зүйл, зорилго, хамрах хүрээ нь харьцангуй явцуу, тухайлбал нягтлан бодох бүртгэлийн стандартууд, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн онцлог, уялдаа холбоог нилээд өргөн тайлбарлаж санхүүгийн тайлангийн тоо мэдээг ашиглан хийх шинжилгээний коэффициентууд, динамик өөрчлөлт, чиг хандлагатай холбоотой арга зүйг түлхүү авч үзсэн байдаг. Тухайлбал, санхүүгийн тайлангийн шинжилгээний судлах зүйл, хамрах хүрээний талаар “Санхүүгийн тайлангийн шинжилгээний судлах зүйл нь хоёр үндсэн урьдчилсан нөхцөл дээр тулгуурладаг. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн загвар, санхүүгийн мэдээллийн утга санаа, ач холбогдол, хязгаарлагдмал байдлыг бүрэн ойлгох явдал юм. Энэ нь санхүүгийн тайлангийн шинжилгээний арга хэрэгслийг зөв ашиглахад чухал ач холбогдолтой.
2. Дараагийн нөхцөл нь эхнийхээсээ үүсэлтэй. Өөрөөр хэлбэл дүгнэлт гаргах зорилгоор санхүүгийн ба үйлдвэрлэлийн нэн чухал хүчин зүйлүүдийг тодорхойлох, нарийвчлан шинжлэхийн тулд санхүүгийн шинжилгээний арга хэрэгслүүдийг чадварлаг ашиглах явдал юм” (Бернстайн, 1996),

“Санхүүгийн тайлангийн шинжилгээ гэсэн нэр томъёог хэрэглэж байгаагийн учир нь санхүүгийн тайлангууд нь санхүүгийн мэдээллийг агуулдагт оршино. Энэ бол шинжилгээнд зөвхөн баланс, орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудыг ашиглана гэсэн үг биш. Гэхдээ санхүүгийн тайлангууд нь шинжилгээний гол судлах зүйл болдог” (Foster, 1986), “Санхүүгийн тайлангийн шинжилгээ нь компанийн үйл ажиллагааны үр дүн ба санхүүгийн байдлыг үнэлэх зорилго бүхий санхүүгийн мэдээллийг тайлбарлах үйл явц юм. Санхүүгийн тайлангийн шинжилгээ нь юуны түрүүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тайлан болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд ба санхүүгийн харьцаануудыг тооцох, тайлбарлах;
2. Санхүүгийн прогноз боловсруулах, үүнд хамгийн чухал нь төсөвлөсөн санхүүгийн тайлан бэлтгэх;
3. Санхүүгийн мэдээллийг авч үзэж байгаа тухайн улс орны онцлог байдлыг судлах;
4. Санхүүгийн тоо мэдээг бэлтгэхэд хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн аргуудад шүүмжлэлтэй хандах явдал юм” (Haskins&Ferris,1996), “Санхүүгийн тайлангийн шинжилгээ нь компани, аж ахуйн нэгжийн өнөө үеийн хүчин чадал, сул талуудыг санхүүгийн тайлан дахь үзүүлэлтүүдээр нь төрөл бүрийн аргачлалаар харьцуулан тооцож, судалж тодорхойлох үйл ажиллагаа юм” (日本政策投資銀行, 2017) гэх зэргээр тодорхойлсон байдаг.

Дээрх байдлаас дүгнэн үзвэл санхүүгийн шинжилгээ нь санхүүгийн тайлангийн шинжилгээнээс илүү өргөн хүрээтэй асуудлуудыг хамарч байгаа бөгөөд түүний гол цөм, сонгодог арга хэрэгсэл нь санхүүгийн тайлангийн шинжилгээний арга зүй болж байна.

Сүүлийн үед санхүүгийн шинжилгээ болон санхүүгийн тайлангийн шинжилгээнд ихээхэн анхаарал хандуулж байгааг барууны зарим эрдэмтэд бизнесийн байгууллагын аж ахуй-санхүүгийн үйл ажиллагаанд хийх шинжилгээг зөвхөн санхүүгийн байдлын шинжилгээгээр хязгаарлаж байна хэмээн шүүмжлэх болсон. “Бид удаан хугацааны туршид, одоо ч бас үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээг санхүүгийн байдлын шинжилгээгээр байнга хязгаарлаж ирлээ. Харин санхүүгийн шинжилгээний талаарх бүтээлүүдэд өөр хоорондоо маш төстэй схем, ашигт ажиллагаа ба төлбөрийн чадварын үзүүлэлтүүдийг сонирхолтойгоор тайлбарлаж, үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны үр дүнгийн бусад үзүүлэлтүүдийг маш даруухан харуулсан байдаг” (Ришар,1997) Үүнээс үзвэл санхүүгийн тайлангийн болон санхүүгийн шинжилгээ нь аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл — санхүүгийн үйл ажиллагаанд иж бүрэн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөхөд учир дутагдалтай болох нь тодорхой байна. Иймээс эрдэмтэд санхүү, эдийн засгийн шинжилгээний арга зүйн асуудалд анхаарал хандуулж, бүртгэлийн Европын загварын гол төлөөлөгч болох Франц, Германы нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн тайлангуудын онцлог болон тэдгээрт хийгдэх шинжилгээний арга зүй нь АНУ болон Английн шинжилгээний арга зүйгээс ялгаатай болох, аж ахуйн үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлтүүдийн аль алиныг нь хамарсан өргөн

хүрээтэй санхүү-эдийн засгийн шинжилгээний арга зүйг авч үзэх шаардлагатай хэмээн дүгнэсэн.

Санхүү, эдийн засгийн шинжилгээний арга зүй нь нягтлан бодох бүртгэлийн зүүн Европын социалист загвар буюу хуучин ЗХУ болон манай улсад өргөн хэрэглэж байсан аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний арга зүйтэй ихээхэн төстэй. Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний чиглэлээр тухайн үеийн ЗХУ-ын эрдэмтэд ихээхэн судалгаа хийж олон тооны ном бүтээл туурвисан байдаг. Тиймээс аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ нь бүртгэлийн Европын загвар болон социалист эдийн засгийн зүй тогтлын аль алиных нь нөлөөллийг агуулсан гэж дүгнэж болно. Иймээс аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний судлах зүйл, зорилго, хамрах хүрээ нь нилээд онцлогтой. “Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ гэдэг бол аж ахуйн төлөвлөгөөний биелэлт, аж ахуйн хөгжлийн явцад зарим хүчин зүйлийн үзүүлэх нөлөөг төлөвлөгөөний үзүүлэлт, тайлан тооцоо болон мэдээллийн эх сурвалжийг боловсруулах замаар системтэй цогцолбор байдлаар судалж, хэмжиж, нэгтгэн дүгнэх арга юм” (Барнгольд,1986), “Аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний судлах зүйл ба агуулга нь:

1. Төлөвлөгөө ба нормативуудын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах;
2. Төлөвлөгөөний биелэлт, нормативуудын мөрдөлтөд бүх талын судалгаа хийх;
3. Хөдөлмөр, материал, санхүүгийн нөөцүүдийн ашиглалтын эдийн засгийн үр ашгийг тодорхойлох;
4. Аж ахуйн тооцооны шаардлагыг биелүүлэхэд хяналт тавих;
5. Дотоод нөөц бололцоог илрүүлэх болон хэмжих;
6. Удирдлагын шийдвэрийн оновчтой байдлыг шалгах явдал юм” (Баканов,1987) хэмээн томъёолсон байна.

Харин эдийн засгийн шинжилгээ нь дээрх шинжилгээний төрлүүдээс илүү өргөн хүрээтэй асуудлуудыг хамарсан байх бөгөөд тухайлбал, шинжилгээний онол, арга зүй, эдийн засгийн шинжилгээ болон бусад шинжлэх ухааны уялдаа холбоо, мэдээлэл хангамж, функционал өртгийн болон иж бүрэн шинжилгээ, үйлдвэрлэл-санхүүгийн үйл ажиллагааны шинжилгээг бүхэлд нь авч үздэг байна. “Эдийн засгийн шинжилгээний судлах зүйлд эдийн засгийн мэдээллийн системээр дамжуулан авч байгаа объектив болон субъектив хүчин зүйлийн нөлөөллөөр бүрэлдэн бий болсон үйлдвэр аж ахуйн газар, нэгдэл холбоодын аж ахуйн үйл явц, тэдгээрийн үйл ажиллагааны санхүүгийн эцсийн үр дүн, нийгэм эдийн засгийн үр ашиг зэргийг ойлгож болно” (Шеремет,1997) гэсэн

нь үүний нотолгоо болно.

Өнөө үед санхүүгийн шинжилгээний, ялангуяа санхүү, эдийн засгийн шинжилгээний цаашдын хөгжлийн чиг хандлагыг юуны түрүүнд шинжилгээний шинэ коэффициентуудыг боловсруулах, түүнчлэн шинжилгээний мэдээллийн баазыг өргөжүүлэхтэй холбон авч үзэж байна. Судлаачид санхүү, эдийн засгийн шинжилгээний үүсэл, хөгжлийн чиг хандлагыг дараах таван чиглэлээр авч үзэж байна. Үүнд:

- Эхний чиглэл бол Empirical Pragmatists School юм. Энэ чиглэлийн төлөөлөгчид нь компанийн зээл авах чадварын судалгааг түлхүү хийсэн бөгөөд санхүүгийн шинжтэй удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн тайлангийн өгөгдлөөр тооцоолж болох олон төрлийн коэффициентуудыг томъёолох анхны оролдлогыг хийсэн.
- Хоёр дахь чиглэл бол Ratio Statisticians School юм. Энэ чиглэлийн төлөөлөгчид статистикийн аргуудыг өргөнөөр ашигласан тусгай коэффициентуудыг ашиглах замаар салбар, дэд салбар болон нэг төрлийн хэсэг, бүлэг компанийн хувьд чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдийн нормативыг боловсруулсан.
- Гурав дахь чиглэл бол Multivariate Modellers School юм. Энэ чиглэлийн төлөөлөгчид нь компанийн цаг үеийн үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлтүүд, тухайлбал хөрөнгө, үйлдвэрлэлийн нөөц, авлагын эргэц түүнчлэн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэх арга зүйг боловсруулсан.
- Дөрөв дэх чиглэл бол Distress Predictors School юм. Энэ чиглэлийн төлөөлөгчид компанийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд, дампуурлаас урьдчилан сэргийлэх арга зам, өнгөрсөн үетэйгээ холбоотой хэтийн чиглэлийн буюу чиг хандлагын шинжилгээний арга зүйг боловсруулсан.
- Тав дахь чиглэл бол Capital Marketers School юм. Энэ чиглэлийн төлөөлөгчид нягтлан бодох бүртгэлийн тайлангийн үнэ цэнэ нь үнэт цаасны эрсдийн түвшин, хөрөнгө оруулалтын үр ашгийн түвшинг урьдчилан тооцоход ашиглагдах боломжтой байх ёстой хэмээн үзэж холбогдох онолын судалгааг хийсэн байдаг.

Дүгнэлт

Манай улсын хувьд социализмын он жилүүдэд ЗХУ-ын тусламжтайгаар шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэл түүнд тулгуурласан аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний арга зүйг ашиглаж, хөгжүүлж

ирсэн. Харин зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойш НББОУС-ыг нэвтрүүлж түүнд тулгуурласан санхүүгийн тайлангийн шинжилгээний арга зүйг нэвтрүүлж, түлхүү ашиглаж ирлээ. Тиймээс бид бүртгэл тайлагнал, шинжилгээний эдгээр загваруудын дэвшилтэт арга зүйг аль алийг нь ашигласан санхүү-эдийн засгийн шинжилгээний арга зүйг өөрийн улс орны пүүс компаниудын онцлогт тохируулан боловсронгуй болгож ашиглах шаардлагатай.

Орчин үед санхүүгийн зах зээлийн түргэн хурдацтай хөгжилтэй уялдаж санхүүгийн нөөцүүдийг оновчтой байршуулах, түүнийг цаг алдалгүй уян хатан хуваарилж ашиглах явдал чухал болж байна. Үүнтэй уялдаж эдийн засгийн шинжилгээний санхүүгийн чиглэл давамгайлах хандлагатай болж байна. Гэхдээ компанийн үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны талыг орхигдуулж болохгүй. Шинжилгээ нь нягтлан бодох бүртгэлийн тайланд суурилсан пүүс компанийн санхүүгийн байдлын хэтийн төлөв, үнэлгээний аргуудыг өөртөө агуулж, юуны түүрүүнд дараах зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна. Үүнд:

- Компанийн санхүүгийн тухайн үеийн байдал болон хэтийн төлвийг үнэлэх
- Компанийн санхүүгийн бодлого, зорилтыг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцүүдийг үнэлэх
- Хөрөнгийн боломжит эх үүсвэрийг илэрхийлэх ба түүнийг дайчлагдсан хэсгийн үр ашгийг үнэлэх
- Капиталын зах зээл дэх компанийн хэтийн төлвийг үнэлэх явдал юм. Үүнийг бид шинжилгээний арга зүйг боловсруулах үзэл баримтлалдаа анхаарах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

Баканов М.И., Шеремет А.Д. *Теория экономического анализа* М, Финансы и статистика М, 1997

Жак Ришар *Аудит и анализ хозяйственной деятельности предприятия* перевод с французской под ред Л.П.Белых. М.Аудит, ЮНИТИ 1997

Ковалев В.В. *Финансовый анализ: Управление капиталом. Выбор инвестиций*

Анализ отчетности. — М.: Финансы и статистика, 1996, 1998

Ковалев В.В. *Введение в финансовый менеджмент* — М.: Финансы и статистика, 2004.

- Ковалев В.В., Ковалев Вит.В. *Финансы предприятий: Учеб.* – М.: ТК Велби, Изд-во Проспект, 2004. с.125
- Панков Д. А. *Бухгалтерский учет и анализ в зарубежных странах : Учебное пособие* Минск. Экоперспектива, 1998
- Радионов Н.В., Радионова С.П, *Основы финансового анализа* СПб. 1999
- Сергеев И.В. “Экономика предприятия: Учеб. пособие. 5-е изд, перераб. и доп. – М. : Финансы и статистика, 2015. -304 с. : ил. с.134
- Томас П. Карлин, Альберт Р.Маклин, *Анализ финансовых отчетов / на основе GAAP/*, М.1999
- Чечевицына Л.Н., Чуев И.Н. *Экономика фирмы: Учебное пособие для студентов вузов.* – Ростов н/Д : Феникс, 2018. с. 85
- Шеремет А.Д, Сайфулин Р.С, *Методика финансового анализа* Инфра М, 1995
- Helfert, E.A. 1994. *Techniques of Financial analysis.* IRWIN. pp.15
- Foster, G. *Financial statement analysis.* Second edition. Stanford University press. 1986
- Haskins, M.E., Ferris, K.R., Selling, T.I., Samuels J.R., Ebrayshaw J .M. *International Financial Reporting and Analysis A. Contextual Emphasis.* 1996
- 日本政策投資銀行 (2017) 「マイナス金利長期化が及ぼす日欧経済への影響について」今月のトピックスNo.280
- 宮尾龍蔵 (2016) 『非伝統的金融政策』 有斐閣